

Ээж надад хэлсэн

Далын Ахлагч Брэдли Д.Фостер

Эхийн хайр Аврагчийн хайртай адил

Хүүхдүүдээ сүнслэг байдлын хувьд өсгөн хүмүүжүүлэх үндсэн үүргийг Их Эзэн эцэг эхчүүдэд оногдуулсан юм. Заримдаа энэхүү үүрэг ганц бие эцэг эхчүүд дээр ирдэг. Аав маань өөд болж, дөрвөн хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх үүрэг ээжийн минь нуруун дээр үлдэхэд тэр харьцангуй залуухан байсан юм. Гэвч ээж минь зовлон зүдгүүрийг итгэл, зоригийн хүчээр даван туулж, үнэний замаас гажилгүй явбал төгсгөл нь эхлэлээсээ дээр байх болно гэж бидэнд амладаг байж билээ. Мормоны Номон дахь бусад баатарлаг эхчүүдийн хүүхдүүдийн адил манай “[ээж] үүнийг мэдэж байсан гэдэгт бид [эргэлздэггүй байлаа].” (Алма 56:48) Ах эгч нар аа, надад эх хүний агуу нөлөөний талаар өөрийн гэсэн ойлголт бий.

Миний сайн найз, Дон Пийрсон тэрхүү нөлөөг онцлон харуулсан нэгэн түүхийг надтай хуваалцсан юм. Нэг орой дөрвөн настай хүү нь түүнээс үлгэрийн ном уншиж өгөхийг хүсчээ. Эрик хамгийн дуртай ном болох *The Ballooning Adventures of Paddy Pork* гэдэг арал дээр амьдарч, нэг арлаас нөгөө арал уруу халуун агаараар дүүргэсэн бөмбөлгөөр нисч аялдаг гэр бүлийн тухай өгүүлдэг номыг сонгосон байлаа. Тэр нь үггүй зурагтай ном байсан учраас Пийрсон ах түүхийг нь зохиож ярьсан аж.

"Падди агаарын бөмбөлгөөр нисэж байна. Тэр одоо нэгэн арал дээр бууж байна. Тэр бөмбөлөгийнхөө хажуунаас утас унжуулж байна" гэхэд нь Эрик түүний яриаг таслан "Ааваа, наадах чинь утас биш ээ, *олс* байхгүй юу" гэж хэлэв.

Пийрсон Ах Эрик уруу нэг харснаа буцаад зурагтай ном уруугаа харан "Падди агаарын бөмбөлөгөөсөө гарч модоор дамжин доош бууж байна. Өө яана аа, цув нь мөчирт тээглэчихлээ!" гэж хэлэхэд, Эрик түүнийг дахин зогсоов. "Ааваа, наадах чинь цув биш ээ, *хүрэм* байхгүй юу" гэв.

Тэгэхэд нь Пийрсон ах тэвдэж эхлэв. "Эрик, энэ номонд чинь үг байхгүй, зөвхөн зураг л байна, Яагаад заавал хүрэм байдаг билээ гэж асуулаа.

Эрик түүнд, "Яагаад гэвэл ээж надад тэгж хэлсэн" гэж хариулжээ.

Аав нь номыг хааж, "Эрик, энэ гэрийн эзэн, эцсийн шийдвэр гаргагч эрх мэдэлтэн нь хэн бэ?" гэж асуув.

Энэ үед Эрик хариултыг өгөхөөсөө өмнө нухацтайхан бодсоноо "Аав аа, та шүү дээ" гэв.

Пийрсон ах хүү уруугаа гэрэлтсэн харцаар харлаа. Ямар лут хариулт вэ! "Чи үүнийг яаж мэдэв?"

Эрик тэр дор нь л "Ээж надад хэлсэн" гэж хариулжээ.

"Энэ ертөнцөд эх хүн болохоос илүү агуу зүйл гэж үгүй. Эх хүний хүүхдүүддээ үзүүлэх нөлөөг хэмжихийн аргагүй юм" гэж Ерөнхийлөгч Жеймс И.Фауст хэлсэн байдаг. ("Fathers, Mothers, Marriage," *Лиакхона*, 2004 оны 8-р сар, 3).

Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх нь тэнгэрлэг загварын дагуу эмэгтэй хүнд өгөгдсөн сүнслэг өвийн нэг хэсэг мэт санагдана. Би энэ зан чанарыг өөрийн охиддоо, дараа нь ач охиддоо мөн харсан. Тэд өөрсдөө хөлд ороогүй байж, хүүхэлдэйгээ арчлан, тэвэрч явахыг хүсдэг.

Би мэргэжлээрээ фермчин, малчин хүн болохоор надад байгалиас заяасан эхийн хайр амьтдад хүртэл байдгийг ажиглан харах сайхан боломж байсан юм. Жил бүрийн хавар бид үхэр сүргээ саяхан гарсан тугалуудынх нь хамт Айдахогийн Снейк голыг өгсүүлэн тууж, тэр хавийн уулсаар сар орчим бэлчээдэг байлаа. Дараа нь бид үхрүүдээ эргүүлэн хашаа уруу нь зам дагуу тууж аваачдаг байсан. Тэндээс үхрүүдээ ачааны машинд ачин Монтана дахь зуны бэлчээрт нь аваачдаг байж билээ.

Нэгэн хаврын бүгчим өдөр би үхрүүдээ хашаа уруу нь тууж аваачихад туслан шороон замаар тоос босгон урагшлах сүргийнхээ араас явж байлаа. Замаас гаран тарж алга болох тугалнуудыг цуглуулж, сүрэгтэй нь нийлүүлж явах нь миний үүрэг байв. Бид маш удаан явж байсан болохоор надад зарим нэг зүйлсийн талаар тунгаан бодох боломж гарсан юм.

Гадаа маш халуун байсан болохоор тугалнууд сүүдэр бараадан мод уруу гүйгээд болохгүй байлаа. Тэр үед нарийн ба шулуун замаасаа гажих Сүмийн өсвөр насныхны талаар би эргэцүүлэн бодсон юм. Би бас замаасаа гаран, Сүмээс хөндийрсөн эсвэл Сүм тэднийг орхисон гэж боддог хүмүүсийн талаар бодож билээ. Тэр үед би замаас гаргах шалтгаан нь заавал хилэнц байх шаардлагагүй, -зүгээр л сүүдэр байж болох юм гэж дотроо бодож билээ.

Олон цагийн турш сүргээсээ салан явах тугалнуудыг цуглуулсаар нүүрийг минь даган хөлс урсахад би цөхөрсөндөө, "Ээжүүдээ дагаад явцгаагаач! Тэд хашаа явахаа мэдэж байгаа! Тэд энэ замаар урьд нь явж байсан!" гэж хашгирав. Замаар явах нь хэдийгээр тоос шороотой, бүгчим халуун байсан ч төгсгөл нь илүү сайхан байх болно гэдгийг үнээнүүд мэдэж байсан болов уу.

Бид сүргээ хашаанд нь оруулахад гурван үнээ хашааны үүдэнд сандран эргэлдэж байхыг бид анзаарав. Тэд тугалаа олохгүй байсан бөгөөд хаа нэгтээ зам дээр хоцорсон болов уу хэмээн мэдэрч байх шиг надад санагдсан. Үхэрчин залуусын нэг нь яах вэ гэж надаас асуув. Би түүнд, "Би тэдний хаана байгааг мэднэ гэдэгтээ мөрийцсөн ч алдахгүй. Эндээс дөрвөн зуугаад метрийн хойно хэсэг мод байсан. Тэнд л байгаа байх" гэв.

Үнэхээр миний таамаглаж байснаар алга болсон тугалнууд модны сүүдэрт унтаж байлаа. Биднийг дөхөж очиход тэд цочин сэрж, тэднийг хураах гэсэн бидний оролдлогыг эсэргүүцэн тэмцэв. Бид тэдний эх нь *биш* болохоор тугалнууд айсан хэрэг! Бид тэднийг хашаа уруу туух гэж хүчлэн чармайх тусам тэд улам их зөрүүдэлж байв. Би эцэст нь үхэрчин залуучуудад хандан, "Уучлаарай залуус аа, надад үүнээс арай дээр нэг санаа байна. Хэдүүлээ хашаа уруугаа буцаж очоод эх үнээнүүдийг нь дагуулаад ирье. Үнээнүүд ирвэл тугалнууд нь дагах байх" гэлээ. Миний зөв байж. Миний бодсоноор үнээнүүд тугалнуудаа яг хаана байгааг мэдэж байлаа. Эх үнээнүүд нь ирж тугалнуудаа дагуулан хашаа уруугаа буцаж явав. Ах эгч нар аа, сонголт хийх эрх чөлөөтэй энэ дэлхийд бидний хайртай хүмүүсийн зарим нь хэсэг хугацааны туршид замаасаа гажин төөрөх нь бий. Гэхдээ бид хэзээ ч

бууж өгч болохгүй. Бид үргэлж тэдний араас явах хэрэгтэй. Бид хэзээ ч хүч чармайлтаа зогсоож болохгүй. Бидний бошиглогч, Ерөнхийлөгч Томас С.Монсон төөрсөн хайрт хүмүүсээ аврах уриалга гаргасан билээ (жишээ нь, "Stand in Your Appointed Place," *Лиахона*, 2003 оны 5-р сар, 54-57-г үз). Санваартны удирдагчдын тусламжтайгаар эцэг эхчүүд алга болсон хайрт хүмүүсээ үргэлж эрж хайн, эргээд ирэхэд нь тэднийг хүлээж авах "орон гэр", гэр бүл, Сүм тэдэнд байгаа гэдгийг батлан харуулж байх хэрэгтэй. Тэдний зүрх сэтгэл хэзээ өөрчлөгдөхийг бид мэдэхгүй. Тэд хэзээ энэ дэлхийн зүйлст эцэж туйлдахыг бид мэдэх аргагүй. Энэ л үед бидний хүүхдүүд Елизабет Акерс Аллены шүлгэнд гардаг шиг сэтгэл догдлом байдлаар ээждээ л ханддаг:

*Уйтгар гунигаар дүүрэн он жилийн давалгаа чи хойшоо буу,
Утга учиргүй хүнд хүчир ажил, зовлон зүдгүүрээс би залхаж байна. . .
Энэ дэлхийн худал хуурмаг, ёс бус, хоосон зүйлсээс залхаж байна,
Ээжээ, ай ээж минь сэтгэл зүрх минь тан уруу тэмүүлнэ!. . .
Эргэлтгүй улиран өнгөрөх өдөр хоногуудад
Эхийн хайр шиг хайрыг зүрх сэтгэлээрээ мэдэрсэнгүй, би;
Энэ дэлхийгээс залхсан оюун бодол, шаналсан зүрхийг
Эхээс минь өөр хэн ч эдгээн тэнхрүүлж эс чадах бөлгөө.
Эцэж ядарсан зовхи минь нойронд дарагдан зүүрмэглэнэ;
Ээж минь та бүүвэйлээч намайг, дахин бүүвэйлээч!*

(*Rock Me to Sleep*, The Family Library of Poetry and Song, ed. William Cullen Bryant [1870], 190-91; цэг тэмдгийг шинэчилсэн.)

Эхийн хайр Аврагчийн хайртай адилхан учраас бид эхийн хайранд бүгд адилхан ханддагийн учир тэр биз ээ."Бусад бүх хайраас жинхэнэ эхийн хайр л Бурханы хайртай хамгийн ойрхон нь" гэж Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит хэлсэн байдаг. ("The Love of Mother," *Improvement Era*, 1910 оны 1-р сар, 278).

Аврагч дэлхийн ээждээ үзүүлсэн хайраар бид бүгдэд төгс үлгэр жишээ үзүүлсэн билээ. Тэр зуурдын амьдралынхаа эцсийн оргил мөчид-Гетсеманид зовж, хуурамч шүүлт, өргөст титэм, хүнд загалмайг тэвчсэний эцэст-, Есүс загалмайн дээрээс доош харан, хүүтэйгээ хамт байхаар ирсэн ээж, Мариагаа олж хараад, амьсгал хураахынхаа өмнө эхийнхээ сайн сайхны төлөө санаа зовж, шавьдаа хандан, "Энэ бол чиний эх!" (Иохан 19:27) гэсэн нь Түүний энэ амьдрал дахь хайрын эцсийн илэрхийлэл байсан юм. Тэрхүү мөчөөс хойш шавь нь Мариаг гэр бүлдээ авсан билээ. Үүний дараа судруудад өгүүлсэнчлэн, Есүс бүх юм зохих ёсоороо биелэгдсэнийг мэдээд толгойгоо гудалгайн хорвоог орхисон билээ. (Иохан 19:28-30-ийг үз)

Өнөөдөр би та бүхний өмнө зогсон Есүс Христ энэ дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч гэдгийг гэрчилж байна. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Түүний Сүм. Бидний Тэнгэрлэг Эцэг бүх хүүхдүүдээ Өөр дээрээ эргэн ирээсэй хэмээн хүсэж байдаг. Ариун Сүнс миний зүрх сэтгэлд ингэж гэрчилсэн учраас үүнийг би ямар ч эргэлзээгүйгээр мэддэг. Би үүнийг дандаа мэддэг байгаагүй. Би бага байхдаа ээж аавынхаа гэрчлэлд найддаг байлаа. Миний ээж амьдралд саад бэрхшээл тааралдсан ч үнэний замаасаа гажилгүй явбал төгсгөл нь эхлэлээсээ дээр байх болно гэж надад батлан хэлдэг байв. Үүнийг надад хэлдэг байсан ээждээ би үүрд баярлан талархаж явах болно. Есүс Христийн нэрээр, амен.

